

МОНГОЛ-ХЯТАДЫН ХАРИЛЦААНЫ ЗАРИМ АСУУДАЛ*Зимин Очир**

Хятадын Синьхуа агентлагийн мэдээлснээр, Улсын Их Хурлын дэд дарга, УИХ дахь Монгол-Хятадын парламентын бүлгийн дарга Гаваагийн Батхүү 2009 оны 1-р сарын 14-ний өдөр Монгол Улс Хятадтай харилцан ашигтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлнэ гэжээ. Тэрээр Монгол Улсад суугаа БНХАУ-ын элчин сайд Юй Хуньяотай хийсэн уулзалт дээр дэлхийн эдийн засгийн байдалд сөргөөр нөлөөлж байгаа санхүүгийн хямралын өнөөгийн нөхцөлд олон улсын санхүүгийн корпорацийг сөрөн зогсохын тулд худалдаа эдийн засгийн харилцаа, харилцан хөрөнгө оруулах ажиллагаагаа бэхжүүлэх шаардлагатай байна гэдгийг цохон тэмдэглэв. Мөн тэрээр гадаадын хөрөнгө оруулалтын сонирхолыг татах, эдийн засгаа хөгжүүлэх үүднээс УИХ Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулна гэжээ.

Сүүлийн жилүүдэд БНХАУ, Монгол Улсын харилцаа амжилттай хөгжиж байгааг Юй Хуньяо цохон тэмдэглээд Монгол Улсад ашигт малтмалыг хурдацтай ашиглах гэж байгаа өнөөгийн нөхцөлд Монголын уул уурхайн аж үйлдвэрийн түүхий эдийг борлуулахад БНХАУ хамгийн аятай зах зээл болно гэв.

Бээжин-Улаанбаатарын хоорондын харилцаа харилцан итгэлцэл, хүндэтгэх байдалтай мэт боловч түүхийг сөхөн харахад, 1911 онд Монголын нийгмийн нэрт төлөөлөгчид болох Жавзандамба хутагт хийгээд халхын дөрвөн хан “Манж-хятадын дарлалыг цаашид тэвчихийн аргагүй болсон учир” Оросын эзэн хаан II Николайд хандан тусламж хүссэх тухай шийдвэр гаргаж Оросын эзэнт гүрний ГЯЯ-нд Монгол Улсын дотоод, гадаад байдлын талаар 21 зүйлт захидал илгээсэн юм. Тухайлбал, захидлын 3-р зүйлд “хятад иргэдэд газар тариалан эрхлэх, Монгол-Хятадын хилийн орчимд оршин суухыг зөвшөөрөх, хятад цэргүүдээр улсын хил мануулах, монгол цэргийг нутгийн гүн руу татах нь цаашид орос, монголын харилцаа болон хоёр орны найрамдалд сөргөөр нөлөөлнө”. 11-р зүйлд “хятадын худаалдаачид хууран мэхэлж байгаа, өндөр үнэтэй бараагаа бидэнд өөрсдийнхээ үнээр хүчээр зарж манай малыг хямдаар

* Зимин Очир - Н.Г.Чернышевскийн нэрэмжит Байгалийн чанад дахь тойргийн нийгэм, багшийн улсын их сургуулийн Зүүн Хойд Азийн олон улс судлалын эрдэм шинжилгээний төвийн шинжээч

худалдан авдаг, өндөр хүүтэй зээл олгож байгаагийн улмаас манай ард түмэн туйлын ядууралд ороод байна. Мөн шинэ татвар авах, гаалийн хураамжыг шинээр тогтоох зэрэг шинэ арга хэмжээ авч байгаад бид цаашид тэвчихийн аргагүй болж байна” гэжээ.

Үүний сацуугаар БНХАУ-ын удирдлага баригчид “Гадаад монгол” гэх нутгийг өөрийн хяналтандаа буцаан авах гэсэн санаанаасаа огтхон ч татгалзаагүй гэдгийг мартаж болохгүй. Энэ байр суурийг Мао Зэдун тухайн үедээ “Хятад улсын шийдвэрлэх зорилго бол Их цагаан хэрэм хүртлэх газар нутагт засаглалаа тогтоогоод зогсохгүй газар нутгаа бүгдийг нь эргүүлэн авах явдал мөн” бөгөөд “Хятадад хувьсгал ялсанаар Гадаад Монгол нь Хятадын холбооны улсын нэг хэсэг нь байх болно” гэж мэдэгдэж байсан юм. “Их гурвын” Ялтын бага хурлын шийдвэрийг Хятад улс хүлээн авч 1945 онд Гадаад Монголын тусгаар тогтнолыг албан ёсоор зөвшөөрсөн билээ. Их гүрнүүд ийм шийдвэр гаргасны дараа ч Мао Зэдун БНМАУ-ыг Хятадад нийлүүлэх хүсэлтийг нэг биш удаа гаргаж байсан юм. 1960-аад оны үед ЗХУ, БНХАУ-ын хооронд гарсан мөргөлдөөнөөс хойш БНХАУ-ын засгийн газраас ЗХУ-д, хожим нь Орос улсад байнга тавьдаг шаардлага бол Монгол Улсаас цэргээ гаргах явдал юм.

Дашрамд дурьдахад өнгөрсөн оны 7-р сард Улаанбаатар хотноо хуралдсан “Монгол, Орос, Хятад: XXI зууны хамтын хөгжил” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээ, практикийн бага хурал дээр энэ асуудлаар ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан М.И.Гольман анхаарал татсан илтгэл тавьсан юм. Тэрээр хятад, монгол судлаач америкийн нэрт эрдэмтэн Генри Шварцын үзэж байгаагаар “Монгол Улсын аюулгүй байдалд гол занал учруулж, цаашид ч занал учруулж болзошгүй асуудал бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр бүрэн эрхээ тогтоох гэсэн Хятадын мөнөөх санаархал мөн” гэдгийг илтгэлдээ цохон тэмдэглэсэн билээ. М.И.Гольман, Г.Шварцаас ишлэл татаж Хятадад хэвлэлийн нийтлэл, газрын зураг зүй зэрэгт албан бус байдлаар Монгол Улсыг Хятадын газар нутгийн салшгүй хэсэг мөн гэсэн ойлголт төрүүлэх, монголчуудыг хятадын 56 үндэстний цөөнхийн нэг гэж хандах илрэл гарч байдгийг тэмдэглэсэн юм.

Илэн далангүй хэлэхэд, монголын тэргүүлэх шинжээчдийн үзэж байгаагаар Монгол Улсад хятадуудын үйл ажиллагааны идэвхтэй байдал монголын ард түмэнд ч улс төрийн удирдлагын ч санааг ихэд зовоох болж байгаа юм. Ийм хандлага олон

жилийн туршид хадгалагдсаар байгаа бөгөөд Бээжингийн эрх баригчид ч энэ асуудлыг зохицуулах, БНХАУ-ын нэр хүндийг монголчуудын өмнө өсгөх хөтөлбөрийг бараг 10 жилийн туршид хэрэгжүүлж байгааг цохон тэмдэглэдэг юм.

Монгол Улсын өмнөд хэсгээр гол төлөв хууль бусаар орж ирсэн хятад ажилчдын байдал нутгийн ард түмэн болон орон нутгийн удирдлагын санааг ихээхэн зовоох боллоо. Тэдгээрийн зарим нь нутгийн иргэдтэй хуурамч болон жинхэнээр гэр бүл болон нутагшдаг нь монгол хүний удмын санд аюул учруулж байна. Үүний сацуугаар хятадтай хил залгаа нутагт хятадын туг далбаа, төрийн сүлд, ханз үсгээр бичсэн зүйл зэрэг хятадын бэлгэ тэмдэгүүд их тархаах түрэмгий байдал ажиглагдах болсон юм.

Хятадууд Монгол Улсын хууль дүрмийг огт хүндэлдэггүй, аж ахуй эрхлэх туйлын бүдүүлэг арга ажиллагаа явуулах, ялангуяа уул уурхайн салбарт ийм байдаг нь олны дургүйг онцгой хүргэж байна. Тухайлбал, “Таван толгойн” уурхайгаас хүнд даацын ачааны тэргээр хятад руу олон жилийн туршид нүүрс тээвэрлэсний улмаас олон зуун хавтгай дөрвөлжин км онгон байгалийг нүүрсний тоосоор дарж, үүний улмаас энэ өргөн удам нутагт хөдөө аж ахуй эрхлэх ямар ч боломжгүй болгоод байна.

Ийм байдал Монгол Улсын бусад газар нутагт ч ажиглагдаж байгааг шинжээчид тэмдэглэдэг юм. Тухайлбал, олон аймгийн нутагт алт олборлохдоо хятадууд олон жилийн туршид хөрс болон орчны усан санг бохирдуулдаг тэсрэх бодис, мөнгөн ус, химийн хорт бодисыг хууль бусаар хэрэглэж байна. Хятадын алт олборлох компаниуд эвдэж сүйтгэсэн газар шороог сэргээсэн жишээ үндсэндээ нэг ч үгүй. Харамсалтай нь тодорхой хэмжээнд эдийн засгийн талаар БНХАУ-аас хараат байдалд байгаа учраас буруутан этгээдэд шийтгэл оногдуулах асуудлыг одоогоор тавихгүй байгаа юм.

Байдал ийм байгаагаас, Бээжингийн эрх баригчдын зээл олгох, буцалтгүй тусламж үзүүлэх, Монголд хятад хэл заах сайн дурын багш нарыг илгээх, төрөл бүрийн шатны төлөөлөгчид, тэдгээрийн дотор орон нутгийн төлөөлөгчдийг ч харилцан солилцох зэрэг суртал ухуулгын чанартай ажиллагаа нь санасан хэмжээний үр дүнгээ өгөхгүй байгаа юм. Монгол Улсын төрийн удирдлагын цөөн хэсэг хүн л Хятадтай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх гэсэн санаатай боловч төрийн түшмэдийн дийлэнх олон үүнээс ихээхэн болгоомжилж байгааг шинжээчид тэмдэглэдэг юм. Гадаадын бусад орнууд Монголын ашигт

малтмалын орд газруудыг ашиглах эрх олохын төлөө шаргуу хөөцөлдөж байхад Хятад улс энэ асуудлыг хэдийнээ еөрт нь ашигтайгаар шийдвэрлэчихсэн мэт идэвхигүй байр суурьтай байгаа нь сэжиг төрүүлж байна. Ажиглагчдын үзэж байгаагаар энэ асуудлаар Монголын улс төрийн эрх мэдэлтнүүд хятадуудын оролцоог төвийн болон орон нутгийн эрх баригчдын түвшинд хатуу хяналтандаа байлгаж, тэдний оролцоог зохих хэмжээнд, бусад орнуудын оролцоотой тэнцвэртэй байлгах шаардлагатай гэж байгаа юм.

Чингис хааны хойч үе өнөөгийн энэ нөхцөл байдлыг тэвчиж чадах эсэхийг цаг хугацаа л харуулах байх.